



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/303

Булган сум

**Гэрээ шууд байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Булган аймгийн Хангал сумын Хялганат тосгоны соёлын төвийн барилгын холболтын зураг төсөв боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан “Өрнөх гүнт” ХХК-тай 20 000 000 (Хорин сая) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

3.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Өрнөх гүнт” ХХК-ийн захирал (Ц.Булганчимэг)-д даалгасугай.

4.Тус ажлыг хууль, журам, гэрээний дагуу орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

11 6323010072